



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/40

Баян-Өндөр сум

Сургалт зохион байгуулах, хөрөнгө
гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2024 оны "Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, заавар батлах тухай" А/38, 2025 оны "Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх, хянах арга хэмжээний төлөвлөгөөг (2025-2028)" батлах тухай А/319 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бүх түвшний эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан сүрьеэ, ХДХВ/БЗДХ, гепатитын чиглэлээр нэгдсэн үйлчилгээ үзүүлэх чадавхижуулах сургалтын удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Сургалтын бэлэн байдлыг хангаж, батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулж ажиллахыг Дархлаажуулалт,зоонозын халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн П.Отгонбилэгт үүрэг болгосугай.
3. Үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах 15,450,800 (Арван таван сая дөрвөн зуун тавин мянга найман зуун) төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данснаас гаргахыг Салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Г.Отгонцэцэгт)-т зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
05 сарын 25-ны өдрийн
А/40 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Бүх түвшний эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдэд
зориулсан сүрьеэ, ХДХВ/БЗДХ, гепатитын чиглэлээр нэгдсэн
үйлчилгээ үзүүлэх чадавхижуулах сургалтын удирдамж

СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ:

Манай улсын хэмжээнд халдварт өвчний нөхцөл байдал, тэр дундаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар, вирусийн гепатитын тархалт нь эрүүл мэндийн салбарын өмнө тулгамдсан асуудлын нэг хэвээр байна.

Улсын хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 52882 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж, 10000 хүн амд 149.2 ногдож байна. Өмнөх оны мөн үеэс 12030 тохиолдлоор буюу 10000 хүн амд ногдох өвчлөл 32.6-оор нэмэгдсэн байна. Халдварт өвчний нас баралтын нийт 80 тохиолдол бүртгэгдсэнээс сүрьеэ (46), улаанбурхан (11), төрөлхийн тэмбүү (9), менингококкт халдвар (5), вируст гепатит (5), бэтэг (1), ёлом (1), тарваган тахал (1), бусад өвчлөл (1) тус тус бүртгэгдсэн байна.

Манай аймаг 2025 онд 971 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэн, 10000 хүн амд 86.8 ногдож, 3 нас/сүрьеэ/ баралт бүртгэгдсэн байна.

Иймээс эрт илрүүлэг, зөв оношилгоо, чанартай эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулахад эрүүл мэндийн ажилтан бүрийн оролцоо нэн чухал юм.

ЗОРИЛГО: Бүх түвшний эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүдийг сүрьеэ, ХДХВ/БЗДХ, гепатитын чиглэлээр нэгдсэн тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхтай болгох, тусламж үйлчилгээг сайжруулах

ЗОРИЛТ:

1. Бүх түвшний эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүдийн сүрьеэ, ХДХВ/БЗДХ, гепатитын талаар мэдлэгийг нэмэгдүүлэх

2. Сүрьеэ, ХДХВ/БЗДХ, гепатитын тусламж үйлчилгээг сайжруулах

ХАМРАХ ХҮРЭЭ: Дархан, Орхон, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл аймгуудын сүрьеэ, ХДХВ/БЗДХ, гепатитын чиглэлээр ажиллаж буй эмч мэргэжилтнүүд

САНХҮҮЖИЛТ: 15,450,800 төгрөг

ХҮРЭХ ҮР ДҮН:

1. Эмч мэргэжилтнүүдийн сүрьеэ, ХДХВ/БЗДХ, гепатитын талаар мэдлэгийг нэмэгдүүлсэн байна

2. Сүрьеэ, ХДХВ/БЗДХ, гепатитын чиглэлээр тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирна.

ХОЁР. СУРГАЛТЫН МОДУЛЬ:

СУРГАЛТЫН ХЭЛБЭР: ТАНХИМ

СУРГАЛТЫН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах мэргэжилтэн
1 дэх өдөр		
8 40-9 00	Бүртгэл сургалтын өмнөх тест	Зохион байгуулагчид
9 00-9 15	Сүрьеэ, ХДХВ/БЗДХ, гепатитын чиглэлээр нэгдсэн үйлчилгээ үзүүлэх чадавхижуулах сургалтын нээлт	Зохион байгуулагчид
9 15-10 00	Сүрьеэ өвчний тархалт Дэлхий дахинд ба Монголд	ХӨСҮТ-ийн СТСА
10 00-10 45	Сүрьеэгийн тархвар зүй	ХӨСҮТ-ийн СТСА
10 45-11 00	Цайны завсарлага	
11 00-11 45	Сүрьеэгийн оношилгоо	ХӨСҮТ-ийн СТСА
11 45-12 30	Сүрьеэгийн эмчилгээ	ХӨСҮТ-ийн СТСА
12 30-13 30	Үдийн хоол	
13:30-14 15	Сүрьеэгийн халдварын сэргийлэлт хяналт	ХӨСҮТ-ийн СТСА
14 15-15 00	Сүрьеэгийн урьдчилан сэргийлэлт	ХӨСҮТ-ийн СТСА
15 00-15 15	Цайны завсарлага	
15 15-16 00	ХДХВ, ДОХ, БЗДХ-ын тархалт Дэлхий дахинд ба Монголд	ДОХ/БЗДХ-ын ТСА
16 00-16 45	ХДХВ/БЗДХ оношилгоо	ДОХ/БЗДХ-ын ТСА
16 45-17 00	ХДХВ/БЗДХ халдварын сэргийлэлт хяналт	ДОХ/БЗДХ-ын ТСА
2 дах өдөр		
840-9.00	Бүртгэл	Зохион байгуулагчид
9.00-9 15	ХДХВ/БЗДХ тархвар зүй	ДОХ/БЗДХ-ын ТСА
9 15-1000	ХДХВ/БЗДХ урьдчилан сэргийлэлт	ДОХ/БЗДХ-ын ТСА
10 00-10 45	ХДХВ/БЗДХ эмчилгээ	ДОХ/БЗДХ-ын ТСА
10 45-11 00	Цайны завсарлага	
11 00-11 45	Гепатитын тархалт: Дэлхий дахинд ба Монголд	ХӨТСА-ны ВГТСТ

11 45-12 30	Гепатитын оношилгоо	ХӨТСА-ны ВГТСТ
12 30-13 30	Үдийн хоол	
13 30-14 15	Гепатитын тандалт	ХӨТСА-ны ВГТСТ
14 15-15 00	Гепатитын халдварын сэргийлэлт, хяналт	ХӨТСА-ны ВГТСТ
15 00-15 15	Цайны завсарлага	
15 15-16 00	Гепатитын эмчилгээ	ХӨТСА-ны ВГТСТ
16 00-16 45	Эхээс хүүхдэд гепатитын В вирусын халдвар дамжихаас сэргийлэх	ХӨТСА-ны ВГТСТ
16 45-17 00	Сургалтын дүгнэлт, сургалтын дараах тест, хаалт	Зохион байгуулагчид

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны
 05 сарын 25-ны өдрийн
 А/40...дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ШААРДАГДАХ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Оролцогчдын хоолны зардал	5хүн*2 өдөр	20	50.000	2,000.000
2	Оролцогчдын замын зардал	Хөвсгөл	400 км х 2 талдаа	3,900	624.000
		Булган	60 км 2 талдаа	3,900	93,600
		Дархан	180 км х 2 талдаа	3.900	280,800
		Сэлэнгэ	290 км х 2 талдаа	3,900	452,400
	Оролцогчдын томилолт	5 хүн х 200.000 х 3 өдөр х 4 аймаг	20	200.000	12 000.000
Нийт дүн					15,450,800